



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 9/108

Арвайхээр сум


Төрийн бус байгууллагаар ажил  
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийг тухайн салбарын төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсүгэй.

2.Нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар төрийн бус байгууллагыг шалгаруулж, гэрээ байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0308

D:My Doc. Zahiramj. Zasag darga